



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 30

Бүрэнхайрхан

Г Санал дэмжих тухай Г

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Булган сумын Далт багийн иргэн Аюуш овогтой Баасанхөхыг төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

2.



ХУРЛЫН ДАРГА Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 31

Бүрэнхайрхан

Өмч хамгаалах зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67, 68 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 31 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: А.Бурмаа - ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүдэд: Т.Нямсүрэн -Сумын 1 дүгээр сургуулийн багш
Д.Батсүрэн -Сумын Минжит Булган цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

Б.Энхцэцэг -Сумын нэгдсэн эмнэлэгийн ажилтан

Ц.Өлзийсүрэн -Сумын цэцэрлэгийн арга зүйч

Ц.Сүхбат -Сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн

Ц.Баасүрэн -Сумын Бүрэнхайрхан багийн иргэн

2.Хууль, тогтоол, журмын биелэлтийг хангаж ажиллах, орон нутгийн өмчит байгууллага, төсвийн бүх шатны эрх баригчид, бүртгэл санхүүгийн ажилтнуудад, хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 05 дугаар сарын 21-ний 51 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 32

Бүрэнхайрхан

Зөрчил арилгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх заалт, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нийтийн эзэмшлийн зам, талбайруу хашаа, граж сунгаж барьсан Булган сум дахь сум дундын Прокурорын газар, иргэн Ч.Энхтуяа, Н.Баянмөнх, О.Түвшинбат, Х.Баясгалан, Н.Ээбаатар, Т.Хоролсүрэн, М.Баттөмөр, Ш.Тасбат, Г.Бадамраа, Г.Ганбат нар нь хууль бусаар сунгаж, дур мэдэн эзэмшсэн газрын зөрчлийг арилгуулсугай.

2.Энэ тогтоолын гарсантай холбогдуулан ажил зохион байгуулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны хагас жилийн хуралдаанаар тайлагнахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 33

Бүрэнхайрхан

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой
үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1."Минжит Булган хот тохижилт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулсугай.
- 2.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх, бүтэц орон тоог батлуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавин ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д даалгасугай.
- 4.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, үүрэг чиглэл өгч ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Т.Батхуяг/-д үүрэг болгосугай.
- 5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 02-ны 02 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн
3.3.тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

**"МИНЖИТ БУЛГАН ХОТ ТОХИЖИЛТ" ОНӨААТҮГ-ЫН
ДҮРЭМ**

2017.04.08.

Бүрэнхайрхан

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.ОНӨААТҮГ-ын "Минжит Булган хот тохижилт" /цаашид тохижилтын алба гэх/-ын дүрмийн зорилго нь орон нутгийн өмчийн нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хогоон байгууламж, усжуулалт, нийтийн халуун ус, улсын болон орон нутгийн чанартай зам талбай, улсын тусгай хамгаалалттай газар нутаг, хилийн боомт орчмын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх мөн шаардлагын дагуу чанартай үзүүлэх бусад харилцааг зохицуулхад оршино.

1.2.Тохижилтын алба нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын захирамж шийдвэр энэхүү дүрмийн хүрээнд сумын Засаг даргын Тамгын газрын дэргэд бие даан үйл ажиллагаа явуулах алба мөн.

ХОЁР.ХЭЛБЭР ОНООСОН НЭР, БАЙРШИЛ, ТЭМДЭГ

2.1.Тохижилтын алба нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой хот тохижилтын алба юм.

2.2.Тохижилтын албаны оноосон нэр "Минжит Булган хот тохижилт" алба.

2.3.Тохижилтын албаны оршин байгаа хаяг:

Аймаг	Ховд
Сум	Булган
Байршил	Далт баг
Шуудангийн хайрцаг
Харилцах утасны дугаар
И-мэйл хаяг

2.4.Тохижилтын алба нь тогтоосон журмын дагуу хийгдсэн албан бичиг, тэмдэг, гэвлэмэл хуудастай байх бөгөөд баталгаажуулсан гарын үсэгтэй байна.

ГУРАВ.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

3.1.Тохижилтын албаны үйл ажиллагааны үндсэн зорилго нь нийтийн эзэмшлийн зам талбай, хашаа хайс, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн ашиглалт,

хамгаалалтад хяналт тавьж засвар үйлчилгээ хийх, улсын болон орон нутгийн чанартай зам талбай, улсын тусгай хамгаалалттай газар нутаг, хилийн боомт орчмын хог хаягдлыг цэвэрлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэх.

3.2.Тохижилтын алба нь сумын хэрэгцээнд зориулсан дараах чиг үүргийг хэрэгжүүлхэд чиглэгдсэн үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

3.2.1.Нийтийн эзэмшлийн зам талбай, хашаа хайс, ногоон байгууламж, гэрэлтүүлгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж засвар үйлчилгээг хийж, арчилж хамгаалах.

3.2.2.Албан байгууллага аж ахуйн нэгж айл өрхүүдтэй гэрээ байгуулан хог хаягдлыг нь цэвэрлэх ажлыг зохион байгуулах.

3.2.3.Улсын болон орон нутгийн чанартай зам талбай, улсын тусгай хамгаалалттай газар нутаг, хилийн боомт орчмын хог хаягдлыг цэвэрлэх.

3.2.4.Иргэдийг цэвэр ундны усаар хангах зорилгоор ашиглагдахгүй байгаа гүний худгуудийг ашиглалтанд оруулах, шинээр хийгдсэн худгийн арчлалт, хамгаалалтыг сайжруулах.

3.2.5.Усны эх гаргах суваг шуудуу татах ажлыг иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх.

3.2.6.Нийтийн халуун усны газрын засвар үйлчилгээ хийх, нэмэгдүүлэх.

3.2.7.Сумын төвийн баяр наадмын талбай, цэнгэлдэх хүрээлэн, ногоон байгууламжуудыг арчлах, усжуулах.

ДӨРӨВ.САНХҮҮГИЙН БҮРТГЭЛ ЭХ ҮҮСВЭР

4.1.Тохижилтын албаны орлого нь дараахь санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ.

4.1.1.Хилийн боомтоор дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслээс орох орлого

4.1.2.Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг

4.1.3.Ажил үйлчилгээнээс олсон орлого

4.1.4.Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

4.1.5.Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэр

4.2.Тохижилтын албаны санхүү нь Нягтлан бодох бүртгэлийн тухай Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон бусад хууль тогтоомжийг мөрддөг болгон ажиллана.

4.3.Нягтлан бодох бүртгэлийн стандарт дүрэм, журам, зааварт нийцүүлэн баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах

4.4.Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг тохижилтын албаны дарга хариуцах бөгөөд тохижилтын албаны орон тоонд гэрээгээр ажиллаж байгаа нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

4.5.Тохижилтын албаны үйл ажиллагаа нь нийтэд ил тод нээлттэй байх ба эрлого бүрдүүлэх, зарцуулалтын үр дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас бүтэн жилээр хэлэлцүүлж илэрсэн алдаа дутагдлыг Засаг дарга хариуцан арилгах ажлыг зохион байгуулан ажиллах

ТАВ.ТОХИЖИЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН ЭРХ ҮҮРЭГ

5.1.Дарга нь дор дурдсан эрх үүрэгтэй байна. Үүнд:

5.1.1.Монгол улсын хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах ба орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хэрэгжүүлхээр төлөөлж гэрээ хэлцэл хийх түүнийг хэрэгжүүлэх.

5.1.2.Санхүүжилтийг батлагдсан хуваарь зориулалтын дагуу зарцуулах.

5.1.3.Үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн өөрт олгосон эрх хэмжээний дотор өмч эд хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, эзэмших, ашиглах, хадгалах, хамгаалах өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

5.1.4.Эрх хэмжээний асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн тохижилтын албаны хэмжээнд дагаж мөрдөх тушаал заавар гаргах.

5.1.5.Тохижилтын албаны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, холбогдох хууль тогтоомжид заагдсаны дагуу захиран зарцуулах.

5.1.6.Даргын эзгүйд үүргийг хэрэнжүүлэх ажилтанг томилон ажиллуулах.

5.1.7.Тохижилтын албыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах.

5.1.8.Шаардлагатай мэдээлэл тухай бүр гаргаж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэр Засаг даргын захирамж хэрэгжүүлж ажиллах.

5.1.9.Хууль тогтоомжид заасан бусад эрхийг хэрэгжүүлэн ажиллаж хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлэх.

ЗУРГАА.ХАРИУЦЛАГА

6.1.Тохижилтын албаны удирдлага нь үйлдвэрийн газрын өмнөөс хувийн эрх ашигтаа нийцүүлэн гэрээ хэлцэл хийж тус газарт хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Тохижилтын алба нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.3.Тохижилтын албаны дарга, нягтлан бодогч, эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.

6.4.Хүлээсэн эрх үүргээ бүрэн биелүүлээгүй бол хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.5.Ажилтан зөрчил гаргавал Хөдөлмөрийн тухай хуулийг үндэслэн сахилгын шийтгэл оногдуулах ба дотоод журмаар зохицуулна.

ДОЛОО.БУСАД

7.1.Сумын Засаг дарга санал болгосноор Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор "Минжит Булган хот тохижилт" ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

7.2.Хуульд нийцүүлэн энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

...оОо...



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 34

Бүрэнхайрхан

Журам батлаж төлбөр тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.12 "д", Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дэх заалт, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Орон нутгийн авто замыг арчлан хамгаалах, цэвэрлэх, засварлах, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах журмыг 1 дүгээр хавсралтаар, Булган суманд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл болон суурьшин амьдарч буй иргэдийн тээврийн хэрэгслээс ногдуулан авах авто зам ашигласны төлбөрийн хувь хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА,  Т.БАТХУЯГ



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн
34-тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖААР ЗОРЧИЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУРААХ ЖУРАМ

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.Монгол улсын “Авто замын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэхь заалтын дагуу орон нутгийн авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс өмчийн хэлбэр, тэдгээрийн харъяаллыг үл харгалзан авто зам ашигласны төлбөр /цаашид төлбөр гэх/ авахад үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг ОНӨААҮГ-ын “Минжит Булган” хот тохижилтын албаны дансанд төвлөрүүлэхийг сумын татварын алба хариуцна.

1.3.Орон нутгийн авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр сумын ЗДТГ-ын санхүүгийн алба, татварын тасаг, сум дундын цагдаагийн хэлтэс болон бусад холбогдох газруудтай ажлаа уялдуулан хамтран ажиллана.

ХОЁР.ОРОН НУТГИЙН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖААР ЗОРЧИЖ БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР НОГДУУЛАН ТӨВЛӨРҮҮЛЭХ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХ

2.1.Сумын Засаг даргын Тамгын газрын татварын алба нь Булган суманд бүртгэлтэй болон тус суманд байнга амьдарч буй иргэдийн тээврийн хэрэгслээс авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг жилд 1 удаа тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэгтэй хамтадган хавсралт 2-т заагдсан хувь хэмжээгээр ногдуулан авч хот тохижилтын албаны дансанд төвлөрүүлнэ. 2.2.Татварын алба нь тээврийн хэрэгслээс авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг хураан авсныг гэрчлэх тасалбар олгох ба тасалбар нь санхүүгийн албаны санхүүгийн тэмдгээр баталгаажсан, огноо, дугаартай үнэт цаас байна.

2.3. Авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн үнэт цаасны тооцоог татварын алба Засаг даргын Тамгын газрын санхүүгийн албатай сар бүр хийж ажиллана.

2.4.Авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн орлогыг орон нутгийн замын арчилгаа, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, замын тэмдэг тэмдэглэгээг бий болгох, сэргээхэд зарцуулж тайланг жил бүрийн эцэст сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж байна.

ГУРАВ.ХАРИУЦЛАГА ТООЦОХ

3.1.Авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн энэхүү журмын 2.1, 2.2-т заасныг зөрчсөн тохиолдолд холбогдох ажилтай албан тушаалтанд зохих хууль тогтоомжын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2.Иргэд, аж ахуйн нэгж байгууллага нь авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг төлөхөөс зайлсхийсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.3.Замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүд авто зам, замын байгууламж ашигласны төлбөр барагдуулсан байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг цагдаагийн хэлтэс хариуцна.

...oOo...

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн
34 тоот тогтоолын 2 дугаар хавсралт

БУЛГАН СУМАНД ОРОН НУТГИЙН ЗАМ АШИГЛАЖ
БАЙГАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС НОГДУУЛАН АВАХ
АВТО ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

Тээврийн хэрэгслийн төрөл	Мотоцикл	Суудлын авто машин, пургон истана	Ачааны авто машин		Автобус 12-с дээш суудалтай
			10 тн хүртэл	10 тн-с дээш	
Хувь хэмжээ /төгрөг/	2000	5000	8000	15000	15000



**ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛГӨЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 25

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам", сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Булган сумын Байгаль багийн иргэн Дорж овогтой Молгогдойт төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.
2. Журмын даруу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА *Дорж*
Т.БАТХҮҮЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 36

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Гончигжав овогтой Мөнхцэцэгийг төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

2.Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 37

Бүрэнхайрхан

Нийгэмлэгийн гишүүдийг шинэчлэн
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар нийгэмлэгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|----------------------|---|
| Нийгэмлэгийн тэргүүн | - Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга |
| Нарийн бичгийн дарга | - Сумын ЗДТГ-ын нийгмийн бодлогын ажилтан |
| Тэргүүлэгч | - Сумын Алагтолгой багийн Засаг дарга
- Сумын ЗДТГ-ын Байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Сумын МЭҮТ-ийн жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн
- Сумын Цагдаагийн хэлтсийн хэв журмын байцаагч
- 1 дүгээр сургуулийн нийгмийн ажилтан
- Минжит Булган цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан
- Сумын ЗДТГ-ын дотоод ажил, эрх зүйн бодлого хариуцсан мэргэжилтэн |

2. Сумын Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар нийгэмлэгийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан хурлаар батлуулж, салбар нийгэмлэгийн ажлыг сурталчлан хүрсэн үр дүнгийн талаар ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Нийгэмлэгийн тэргүүн, нарийн бичгийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Т. БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 38

Бүрэнхайрхан

Г Нийгмийн эрүүл мэндийн салбар Ү
зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.1.7 дахь заалт, Эрүүл мэндийн тухай Монгол улсын хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 425 дугаар тогтоол, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: -Сумын Засаг дарга

Орлогч дарга: -Нэгдсэн эмнэлгийн дарга

Гишүүдэд: -Нийгмийн бодлого хариуцсан Засаг даргын орлогч

-Санхүү албаны дарга

-Минжит Булган цогцолбор сургуулийн захирал

-1 бүрэн дунд сургуулийн захирал

-Соёлын ордоны захирал

-Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга

-Булган хатан заяа ТББ-ын тэргүүн

Нарийн бичгийн дарга: -Нийгмийн эрүүл мэндийн ажилтан

2.Холбогдох хууль тогтоол, шийдвэрүүдийг үндэслэн ажлын төлөвлөгөө гарган ард иргэдийн эрүүл мэндийн боловсрол ханган, эмнэлгийн анхны мэдэгдэхүүнтэй болгож ажиллахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 08 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 39

Бүрэнхайрхан

Төсөл сонгон шалгаруулах зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “В”, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалтуудыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга –Б.Амгаланбадрах -Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга-Д.Энхболд –Санхүү албаны дарга

Гишүүдэд: Ш.Азжаргал -Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

Х.Нэгдэлхаан –Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн

Х.Бат-Амгалан -Иргэний төлөөлөл

Н.Хосбаяр -Иргэний төлөөлөл

Б.Ганзориг –Иргэний төлөөлөл

2.Сум хөгжүүлэх сангийн журмыг дагаж мөрдөх, орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллахыг зөвлөлийн дарга /Б.Амгаланбадрах/-д даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2014 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 21 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 40

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Булган сумын уугуул Улаанбаатар хотын иргэн Манжаа овогтой Алтанцэцэгийг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

2.Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 41


Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Булган сумын уугуул Улаанбаатар хотын иргэн Намжил овогтой Сарангэрэлийг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт саналыг дэмжсүгэй.

2.Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 42

Бүрэнхайрхан

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн авто замыг арчлах хамгаалах, цэвэрлэх, засварлах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор гарсан тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 34 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 43

Бүрэнхайрхан

Хандивын аян өрнүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.1.7 дахь заалт, сум, багийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Тус сумын Баянгол багийн иргэн Б.Пүрэвдоржийн хүү П.Батхуяг нь түнхэний мултралын хүнд гэмтлийн улмаас гадаадад гарч хагалгаа хийлгэх шаардлагатай байгаа тул эмчилгээний зардалд дэм тус болох зорилгоор хандивын аяныг сумын хэмжээнд өрнүүлсүгэй.

2.Баг, байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд иргэн П.Батхуягт сайн санааны дэмжлэг үзүүлэхийг уриалсугай.

3.Хандивын аяныг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 44

Бүрэнхайрхан

Санал уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дүгээр зүйлийн 20.1.14 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг дэмжсүгэй.

2.Иргэн, ААН, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зорилгоор эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг 1 дүгээр хавсралтаар, иргэнд эзэмшиж байгаа хашааны газрыг нь үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээг 2 дугаар хавсралтаар, иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газрын байршил хэмжээг 3 дугаар хавсралтаар, гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж, байгууллагад төмс хүнсний ногоо, таримал мод, ургамал тариалах зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг 4 дүгээр хавсралтаар, газрыг элэгдэл эвдрэл, доройтлоос хамгаалах нөхөн сэргээх газрын байршил, хэмжээг 5 дугаар хавсралтаар, эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээг 6 дугаар хавсралтаар, төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх газрын байршил хэмжээг 7 дугаар хавсралтаар тус тус уламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ



Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх, газрын байршил, хэмжээ, хөрөнгө оруулалт

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Талбайн солбицол	Газрын хэмжээ га	Газрын хэмжээ м2	Зориулалт	Харэгжүүлэх хугацаа/улирал сараар /				Хөрөнгө оруулалтын хэмжээ мян. төг	Хариуцах эзэн	
								I	II	III	IV			
1	Булган	Далт	Ягшийн хар толгойн доод талд Баянгол багийн төв явах зам дагуу	46 07 17.2, 91 34 30.5	1		Махан зоорь, мал нядалгааны газар		*	*	*		СЗД,ГД, БОУХБ,БЗД Цагдаа	
			Увш хааны 6-15 тоот			61.7	Дэлгүүр		*	*	*		СЗД,ГД, БОУХБ,БЗД Цагдаа	
			Увш хааны 7-59 тоот			45.5	Дэлгүүр		*	*	*		СЗД,ГД, БОУХБ,БЗД Цагдаа	
		Бүрэнхайрхан	Увш хааны 7-48 тоот			46.8	Дэлгүүр		*	*	*		СЗД,ГД, БОУХБ,БЗД Цагдаа	
			Баянсудал	Иргэн Т.Жумажаны хойд талд	46 04 29.97, 91 33 37.45	0.02	200	Үйлчилгээний зориулалтаар		*	*	*		СЗД,ГД, БОУХБ,БЗД Цагдаа
				Баянсудал багийн төвийн замын эсрэг талд	46 04 17.80, 91 33 54.58			100	Юнителийн сайт байрлуулах		*	*	*	
Нийт				1.02	454									

**Иргэнд эзэмшиж байгаа хашааны газрыг нь
үнэгүй өмчлүүлэх газрын байршил, хэмжээ**

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Байршилын солбицол	Өрхийн тоо	Газрын хэмжээ га	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/												Хариуцах эзэн	
							I			II			III			IV				
							I	II	III	I	II	III	I	II	III	I	II	III		
1	Булган	Далт	Хайрхан 2-12 тоот		2	0.57						*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД	
			Хайрхан 2-16 тоот		1	0.50							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Бадам баатар 1-33а тоот		1	0.13							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Далтын ам 8-14 тоот		1	0.30							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Далтын ам 7-02 тоот		1	0.31							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Атрын торны эхэнд		1	0.50							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Бадам баатар 2-02б тоот		1	0.07							*	*						СЗД,ГД, БЗД
		Бүрэнхайрхан	Баазын цагаан 1-11 тоот		1	0.23							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Ахуй 6-01а тоот		1	0.07							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Бааз 1-02б тоот		1	0.15							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Э.Шилэг баатар 1-09а тоот		1	0.07							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Цагаан чулуут 2-30 тоот		4	0.76							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Ахуй 6-00 тоот		1	0.14							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Ахуй 6-06 тоот		1	0.12							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Ахуй 5-07 тоот		1	0.12							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Ахуй 8-16 тоот		1	0.12							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Ахуй 3-01 тоот		1	0.15							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Ахуй 3-03 тоот		1	0.20							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			хоршоолол 1-11а тоот		1	0.10							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
			Баянсудал	Цоохор нуур 4-20 тоот		1	0.50							*	*	*	*	*	*	*
		Цоохор нуурын 3-01а тоот			1	0.44							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
		Булагт харын 4-15 тоот			1	0.50							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
		Булагт харын 4-17 тоот			1	0.50							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД
Булагт харын 2-02 тоот		2		1.00							*	*	*	*	*	*	*	СЗД,ГД, БЗД		
	Нийт																			

Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр өмчлүүлэх газрын байршил, хэмжээ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Талбайн солбицол	Өрх-ийн тоо	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа												Хариуцах эзэн
								I			II			III			IV			
								1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Булган	Баянсудал	Булагт хар 3-03 тоот		1	0.075	ГБХ					*	*	*	*	*	*	СЗД, ГД		
2	Булган	Баянсудал	Хоршоолол 4-22 тоот		1	0.1	ГБХ					*	*	*	*	*	*	СЗД, ГД		
	Нийт				2	0.175														

...оОо...

**Гэр бүлийн хэрэгцээнд болон аж ахуйн нэгж, байгууллагад төмс,
хүнсний ногоо, таримал мод, ургамал тариалах зориулалтаар
эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ**

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Талбайн солбилцол	Газрын хэмжээ /га/	Зориулалт	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Хэрэгжүүлэх хугацаа												Хариуцах эзэн
								/уулир, н, сараар/												
								I			II			III			IV			
								1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
			Эргэнэг		0.50	ГБХ	1					*	*	*	*	*		СЗД,Газрын даамал		
			Бадам баатар 2-18 тоот		3.38	Тариа ногоо тарих, ойжуулах	1					*	*	*	*	*		СЗД,Газрын даамал		
			Хайрхан 2-12а тоот		1.78	Тариа ногоо тарих	1					*	*	*	*	*		СЗД,Газрын даамал		
			Хайрхан 2-16а тоот		2.57	Тариа ногоо тарих	1					*	*	*	*	*		СЗД,Газрын даамал		
			Ягш 3-12 тоот		0.41	Тариа ногоо тарих	1					*	*	*	*	*		СЗД,Газрын даамал		
			Атрын торны эхэнд		2.16	Тариа ногоо тарих, ойжуулах	1					*	*	*	*	*		СЗД,Газрын даамал		
		Бүрэнхайрхан	Э.Шилэг баатар 1-47 тоот		2	0.15						*	*	*	*	*		,ГД, БЗД		
		Баянсудал	Хар үзүүр		1.90	хамгаалах, ойжуулах	1					*	*	*	*	*		СЗД,Газрын даамал		
	Нийт				14.70		7													

Газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах нөхөн сэргээх газрын байршил, хэмжээ


№	Сумын нэр	Багийн нэр	Байр-шил	Хийгдэх ажил	Газрын хэмжээ /га/	Талбайн солбилцол	Нийт хөр-өнгө /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа																Хариуцах эзэн		
								үүнээс			/улирал, сараар/															
								улсын төсөв /сая.төг/	орон нутг-ийн төсөв /сая. Төг/	ААНБ-ын хөрөнгө /сая.төг/	I			II			III			IV						
											1	2	3	4	5	6	7	8	9	10	10	11	12			
1	Булган	Баянсудал	Доод нарийн	Нөхөн сэргээх	4										*	*	*	*	*					СЗД,ГД		
		Байтаг	Их улаан толгой	Нөхөн сэргээх	9											*	*	*	*	*					СЗД,ГД	
			Цөмөрдөг толгой	Нөхөн сэргээх	3											*	*	*	*	*					СЗД,ГД	
		Алагтолгой	Мянгадын хөтөл	Нөхөн сэргээх	0.4											*	*	*	*	*						СЗД,ГД
			Тэмээний хонд	Нөхөн сэргээх	4											*	*	*	*	*						СЗД,ГД
			Сухайт	Нөхөн сэргээх	4											*	*	*	*	*						СЗД,ГД
	Бүрэнхайрхан	Хуучин карьерь	Нөхөн сэргээх бүх нийтийн амралттын газар болгох	6.6										*	*	*	*	*						СЗД,ГД		
	Нийт				31.0																					

Эрчимжсэн мал аж ахуйн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Талбайн солбицол	Төлөвлөж буй газрын нийт хэмжээ /га/	Иргэн, аж ахуйн нэгж байгууллага	Зориулалт	Харэгжүүлэх хугацаа/улирны сараар /				Хариуцах эзэн
								I	II	III	IV	
1	Булган	Алагтолгой	Борзонтын дугуйд		7	1	Эрчимжсэн мал аж ахуй /сүүний чиглэлийн үхэр/		*	*		СЗД, Газрын даамал
	Нийт				7	1						

...ооо...

Булган сумын 2017 оны ИТХ-ын Тэргүүлэгчдийн
хуралдааны ... тогтоолын 7 дугаар хавсралт



Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд зориулан эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил	Нэг иргэнд эзэмшүүлэх газрын хэмжээ /га/	Зориулалт	Төлөвлөж буй газрын нийт хэмжээ /га/	Хэрэгжүүлэх				Хариуцах эзэн
							I	II	III	IV	
1	Булган	Бүрэнхайрхан	Нисэх 3-05 тоот	1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны байр	0.075			*	*	СЗД,ГД , БОХУБ
	Нийт			1		0.075					

...oOo...



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 45

Бүрэнхайрхан

Хуралдааны тов зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удидлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдааныг 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдөр зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.

1.1.Сумын 2017 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай илтгэл

1.2.Сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай илтгэл

Хоёр.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээлэл, материалыг хувилан төлөөлөгчдөд хүргүүлэхийг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

Гурав.Хуралдааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 46

Бүрэнхайрхан

Түр хугацаанд малын хөл
хөдөлгөөнөөс чөлөөлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удидлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, сумын Засаг даргын саналыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Булган гол Их онгогийн Байгалийн цогцолборт газрын Бага онгог, Их онгог хэмээх газарт ургадаг нэн ховор ургамал Чийр /залаархаг хаврага/-ийн ид ургалтын үе жил бүрийн 05 дугаар сарын 01-ээс 06 дугаар сарын 01, үр боловсорч унах хугацаа 08 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 01-ны хооронд тус газрыг дурьдсан хугацаанд малын хөлөөс чөлөөлсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Т.БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 47.

Бүрэнхайрхан

Тогтоолд өөрчлөлт
оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удидлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар хуралдааныг “2017 оны 06 дугаар сарын 13-ны өдөр зарлан хуралдуулж” гэснийг 2017 оны 06 дугаар сарын 15-нд хуралдуулан гэж өөрчилсүгэй.



ХУРЛЫН ДАРГА *[Signature]* БАТХУЯГ



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 48

Бүрэнхайрхан

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.14 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016-2020 оны үйл ажиллагааны стратеги, бүтцийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардагдах төсвийн хэрэгцээг шийдвэрлэж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Т.Батхуяг/-д үүрэг болгосугай.

3.Стратеги, бүтцийн хөтөлбөрийн үйл ажиллагааны зорилтыг сум, багийн онцлогтой уялдуулан ирэх 4 жилийн нутгийн удирдлагын бодлого, үйл ажиллагаандаа тусган мөрдөж ажиллахыг багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.

4.Хөтөлбөрийн үйл ажиллагааны зорилтыг жил бүрийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын төлөвлөгөөнд тусган батлуулж хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулан үр дүнг тооцож хагас, бүтэн жилээр Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Т.БАТХУЯГ





СУМЫН ИТХ-ЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ХӨТӨЛБӨР

1.1. Оршил

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /ИТХ/-ын үйл ажиллагааны стратеги бүтцийн хөтөлбөрийн зорилго нь сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, өгөөжийг тогтвортой дээшлүүлэх, сумын эдийн засаг, нийгмийн ногоон хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх, орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлж үр ашгийг дээшлүүлэх, хүний хөөцийн удирдлагын манлайллыг хангах, сургалт зохион байгуулах талаарх стратеги болон бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

-Монгол Улсын Үндсэн хууль

-Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль

-Монгол Улсын төсвийн тухай хууль

-Монгол улсын татварын багц хуулиуд

-Монгол улсын Газрын тухай багц хуулиуд

-Монгол Улсын төрийн албаны тухай хууль

-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

-Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль

-Шилэн дансны тухай хууль

-Сонгуулийн тухай хууль

-Холбогдох бусад хууль тогтоомж

1.3. Стратегийн удирдлага, зохицуулалтын үндсэн хэрэглэгч

Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч хамрагдана.

-Орон нутгийн иргэд

-Сумын өмчийн бүх хэвшлийг хуулийн этгээд

-Сумын НӨУБ-ын сонгууль, ажилтнууд

-Сумын ИТХ-ын стратегийн удирдлага нь дээр дурдсан үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангах, үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоож, ажлын албаны үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын ажлын

байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

ХОЁР. Сумын ИТХ-ын үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратеги мөн чанар

Сумын ИТХ-ын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр багийн хурал, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэн зохион байгуулж иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Сумын ИТХ нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй байна.

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагаа бүхий бүтцийн оновчтой тогтолцооны шилжүүлэн төлөвшүүлнэ.

2. Олон таллуурт ногоон хөгжлийн эдийн засагт суурилсан сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өсөлтийг хангаж, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх бодлогыг тодорхойлон хэрэгжүүлнэ.

3. Орон нутгийн өмчийн оновчтой бодлогыг хэрэгжүүлж үр ашгийг дээшлүүлнэ.

4. Нээлтэй, ил тод, шуурхай, чанартай хүртээмжтэй үйлчилгээг иргэд, хуулийн этгээдэд үзүүлнэ.

2.3. Эрхэм зорилго

Сумын ИТХ-ын эрхэм зорилго нь: Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадварлаг, нээлтэй, ил тод болгон төлөвшүүлж иргэдийн оролцоотой эдийн засаг, нийгмийн ногоон хөгжлийн хүрээнд уламжлал-шинэчлэлийн уялдааг ханган олон таллуурт эдийн засгийн болон хүний хөгжлийг дэмжсэн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж олон үндэстэн, ястан ард түмний аж амьдралыг дээшлүүлэн ая тухтай ажлаж амьдрах нөхцөл бүрдүүлэхэд оршино.

2.3. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дээрх эрхэм зорилгод хүрэхийн тулд үйл ажиллагааны дор дурдсан стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ.

Стратегийн зорилт 1: Сумын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр өгөөжийг тогтвортой дээшлүүлэх

Стратегийн зорилт 2: Сумын эдийн засаг, нийгмийн олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлж хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангах хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх

Стратегийн зорилт 3: Орон нутгийн өмчийн өмчлөгчийн эрх мэдлийг хэрэгжүүлж үр ашгийг дээшлүүлэх

Стратегийн зорилт 4: Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах

2.5. Үйл ажиллагааны гол зорилт: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана.

Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Сумын ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг судалгаа хийж төгс боловсруулан нийтийн эрх ашигт нийцсэн оновчтой шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэх, биелэлтийг хангахад хяналт тавьж үр дүнг тооцох

1.2. Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх

1.3. Сумын ИТХ-ын бүтцийн байгууллагууд /Хурлын хороод, намын бүлэг/-ын үйл ажиллагааг тогтмолжуулах

1.4. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтвортой, үр нөлөөтэй үйл ажиллагааг бий болгох

1.5. Багийн ИНХ-ын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх

1.6. Орон нутгийн НӨУБ-ын сонгуультаан ажилтнуудад мэдээлэл олгох сургалт сурталчилгааг зохион байгуулах

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн алс хэтийн болон жил бүрийн үндсэн чиглэлийн хөгжлийн хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтарч боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулж үр дүнг тооцох

2.2.Холбогдох байгууллагуудтай хамтарч сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн цаг үеийн тулгамдаж буй асуудлаар судалгаа, шинэжилгээ хийж санал боловсруулах, батлуулах, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж үр дүнг тооцох

2.3.Орон нутгийн төсөв боловсруулах, хэлэлцэж батлах, хэрэгжилтэнд хяналт тавьж гүйцэтгэлийг батлах

2.4.Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг дүгнэх, үнэлэх

2.5.Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглахаар төлөвлөх, батлах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хөтөлбөр батлах, хэрэгжилтэнд хяналт тавих, үр дүнг тооцох

2.6.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар түүний харъяа байгууллагууд, Хурлын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянан шалгах

2.7.Олон нийтийн үүсгэл санаачлагыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1.Орон нутгийн өмчийг хувьчлах бодлого, хувьчилж үл болох хөрөнгийн жагсаалт батлах

3.2.Орон нутгийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгийг түрээслэх, орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг данснаас хасах /худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах/ шинээр авах, өмчийг эзэмшүүлэх, өмч хамгаалах зөвлөл ажиллуулах, өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх зэрэг журмуудыг баталж хэрэгжүүлэх

3.3.Орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах

3.4.Орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот газруудын дүрмийг баталж өмчийн төлөөллийг хэрэгжүүлэн мөрдөх норм нормативуудыг тогтоох

ХТ-10-000

Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1.НӨУБ-ын чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх чадварлаг боловсон хүчний нөөц бүрдүүлж гүйцэтгэлийн удирдлага, хариуцлага, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх

4.2.Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үйл ажиллагааг төлөвлөх, удирдлагын манлайллыг хангах

4.3.НӨУБ-ын сонгуультаан ажилтнуудад зохион байгуулалтын болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

4.4.Хүний нөөцийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилтнуудын мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар, манайллыг хангах

2.6.Үйл ажиллагааны зорилт

Сумын ИТХ-ын үйл ажиллагааны гол зорилтыг зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

ГУРАВ.СУМЫН ИТХ-ЫН БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН НЭГЖИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Сумын ИТХ-ын үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

3.1.1.Хууль дээдэлсэн байх: Үйл ажиллагаандаа хуулийг дээдлэн сахиж мэргэжлийн өндөр чадвартай ажилтнууд стандарт, шалгуур бүхий гүйцэтгэлийн удирдлага, хяналтын тогтолцоогоор дамжин боловсруулагдаж, баталгаажсан төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, хүртээмжтэй хүргэхээр зохион байгуулах тогтолцоог бүрдүүлэх


3.1.2.Бүтээлч байх: Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Нутгийн өөрөө удирдах байгууллага нь зохион байгуулалт, ажил үүрэг, санхүүгийн хувьд хараат бус байж иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагаа явуулах, Засаг дарга болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, тайлагнахад аливаа нөлөөнд автахгүй байж ажлын үр дүнг нотлох баримтад түшиглэн боловсруулж, тэнцвэртэй, бодитой мэдээллийг түгээнэ

3.1.3.Ил тод байх: Бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэд, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн санал санаачлага оролцоог нэмэгдүүлж нээлттэй, ил тод, шударга, хурдтай байхын зэрэгцээ бодитой үнэн зөв мэдээ, мэдээллийг ашигладаг байх.

3.2.Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Сумын ИТХ-ын үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн зохион байгуулалтын бүтцийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна.

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН АЖЛЫН АЛБАНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ



ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

1. Сумын ИТХ-ын даргын чиг үүрэг:

1.1.Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн хамт дараах асуудлыг хариуцаж хэрэгжүүлнэ.

1.2.Сумын ИТХ, Тэргүүлэгч, Төлөөлөгчид, хороо, түр хороо, ажлын албаны ажлыг нэгдсэн удирдлагаар хангах.

1.3.Сумын эдийн засаг, нийгэм, соёлын болон нийт салбарын хөгжлийн асуудлыг цогцоор авч нэгдсэн удирдлагаар хангах.

1.4.Сумын ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, хурлын бүрэн эрх, иргэдийн нийтлэг эрх ашгийг хөндсөн тулгамдсан асуудлыг бүх шатны хурал, Засаг дарга, хууль хяналтын болон бусад байгууллагуудтай харилцаж зохицуулах.

1.5.Сумын төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих

1.6.Хурлын төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд ажлын албаны төсвийн зарцуулалтанд хяналт тавих

1.7.Орон нутгийн өмчийн бүрдүүлэлт зарцуулалтанд хяналт тавьж, хөрөнгийн асуудлыг ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаанаар шийдвэрлүүлэх

1.8.Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн талаар дэвшүүлсэн тухайн жилийн зорилтын биелэлтэнд хяналт тавьж биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулах

1.9.Сумын ИТХ-ын байгууллагын гадаад харилцааны асуудлыг нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөн хариуцах

1.10.Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Улаанзагалмайн хороо, цагаатгалын салбар комисс зэрэг төрийн дээд шатны байгууллагын шийдвэрээр хүлээлгэсэн сонгуульт ажил үүргийг хариуцах

1.11.Төлөөлөгчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд нь холбогдох газруудтай ярьж туслах, төлөөлөгчдөөс хэвлэмэл хуудсаар байгууллага, албан тушаалтанд тавьсан асуулга, санал, шаардлагын мөрөөр хийх ажлыг зохион байгуулж, биелэлт үр дүнг нэгтгэн Төлөөлөгчид болон ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулах.

1.12.Булган сумаас сонгогдсон УИХ-ын гишүүд, аймаг, сумын ИТХ-ын Төлөөлөгчдийг нэг баг болгон ажиллуулах, иргэдтэй уулзуулах, тайлан хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах.

1.13.Хурлын төсвийн менежертэй менежерийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, үнэлж, дүгнэх

2.Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Ажлын албаны даргын чиг үүрэг:

2.1.Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албыг өдөр тутмын ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, ажилтнуудтай үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулж, дүгнэж ажиллах

2.2.Сумын ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэлийг хангах, холбогдох байгууллагуудад үүрэг, чиглэл өгөх, хурлаас гарах шийдвэрийн төсөлболовсруулах

2.3.Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн ажилд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах

2.4.Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг нэгдсэн зохион байгуулалтаар хангах

2.5.Сумын ИТХ-ын жил, улирлын ажлын төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож иргэдэд улирал бүр мэдээлэх

2.6.Хуралдааны илтгэл мэдээллийг шивэх

2.7.УИХ, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн ИТХ-ын сонгууль, нөхөн сонгууль, санал асуулгын бэлтгэлийг хуулийн дагуу хангаж, зохион байгуулах, хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

2.8.Сумын ИТХ-ын ажлын албаны дотоод журмын биелэлтэнд хяналт тавьж, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэх.

2.9.Сумын Засаг дарга, түүний Тамгын газар, бусад байгууллагуудтай харилцах харилцааг зохион байгуулах

2.10.Сумын ИТХ-ын гадаад харилцааны асуудлыг зохион байгуулах

2.11.Нутгийн удирдлагын холбооны ажлыг зохион байгуулах.

2.12.Сумын ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан ажил хэргийн тогтоолын биелэлтэнд хяналт тавих, үр дүнг Тэргүүлэгчдийн хуралдаанд улирал бүр танилцуулж ажиллах

2.13.Ажлын албаны төсвийг уялдуулан зарцуулах

2.14.Сумын ИТХ-ын жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчид хянуулж, Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн санд өгөх.

2.15. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны санхүү, өмч хөрөнгийн бүртгэл хөтөлөх, төсвийн жил, улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж зохиох байгууллагад хүргүүлэх.

2.16. Сумын ИТХ-ын даргад бодлогын болон үйл ажиллагааны ажилд шуурхай дэмжлэг үзүүлэх ажиглагаг зохион байгуулах

2.17. Холбогдох асуудлаар иргэд, байгууллагын өргөдөл, гомдол, эрэлт хүсэлтийг судлан шийдвэрлэж хариу өгөх.

2.18. Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах ажлыг хянаж бэлтгүүлэх.

2.19. Хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж зохион байгуулах, ажлын үйлдээ холбоот хангах

2.20. Хурлын үйл ажиллагааны чиглэлээр сумын Засаг даргын Тамгын газар болон бусад байгууллагадтай харилцах, хамтын ажиллагааг хангах

2.21. Байгйн ИТХ-ын ажлыг үнэлж дүгнэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах

2.22. Холбогдох хууль тогтоомж, хурлын шийдвэрийг сурталчлан биелэлтийг хангах, үр дүнд хяналт үнэлгээ хийх.

2.23. Сумын ИТХ-ын төлөөлөгчид болон байгйн ИТХ-ын дарга, сонгуультагүүдийг сургалтанд хамруулах, чадавхижуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх.

2.24. Хурлын харьяа байгууллагууд болон төсөл хөтөлбөр, ТББ, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажлаж тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

2.24. Хурлын харьяа байгууллагууд болон төсөл хөтөлбөр, ТББ, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажлаж тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

ДӨРӨВ: БОЛОВСОН ХҮЧНИЙ БОДЛОГО, ХЭРЭГЦЭЭ

4.1. Боловсон хүчний бодлого: Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх чадвар бүхий боловсон хүчний нөөц бүрдүүлж, гүйцэтгэлийн удирдлага, хариуцлага, урамшууллын дэвшилтэт тогтолцоо нэвтрүүлэнэ.

4.1.1. Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан тушаалтны ажлын байрны хэрэгцээ шаардлагыг шинэчлэн тодорхойлж, түүнд чиглэсэн боловсон хүчний бодлогыг авч хэрэгжүүлнэ.

4.1.2. Удирдах ажилтны удирдах арга барилыг сайжруулж, манлайлаг бий болгоно.

4.1.3.Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг удирдах, хянах, үр дүнг үнэн зөв үнэлж дүгнэх, урамшуулах тогтолцоог сайжруулна.

4.1.4.Ажилтан, төлөөлөгчдийн мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж, ажилтнуудын мэргэжлийн өндөр мэдлэг, чадвар болон манлайллыг хангаж ажиллана.

4.1.5.Сургалт, судалгаанд шилдэг туршлага, арга зүйг сурч эзэмших, үйл ажиллагаанд нэвтрүүлэх явцад дэвшил гарна.

4.2.Сумын ИТХ-ын 2016-2020 оны боловсон хүчний хэрэгцээ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Ажиллагсадын орон тоо					
Бүгд	9	9	10	10	10
Удирдах ажилтан	1	1	1	1	1
Гүйцэтгэх ажилтан	1	1	1	1	1
Үйлчлэх ажилтан	1	1	2	2	2
Гэрээт	6	6	6	6	6

ТАВ: СУМЫН ИТХ-ЫН САНХҮҮГИЙН ХЭРЭГЦЭЭ

БУЛГАН СУМЫН ИТХ-ЫН 2014-2016 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ ,2017 ОНЫ ТӨСӨВ 2018-2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ

КОД	Үзүүлэлт	ИТХ			ИТХ			
		2014 оны гүйцэтгэл	2015 оны гүйцэтгэл	2016 оны гүйцэтгэл	2017 оны батлагдсан	төсөөлөл		
						2018 он	2019 он	2020 он
	Урсгал зардалын дүн	66262.2	55196.7	50,752.0	50,551.3	62,863.1	67,193.1	70,446.6
А	Бараа үйлчилгээний зардал	60,927.9	55,196.7	50,752.0	48,551.3	60,567.1	64,897.1	68,150.6
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшил	48,123.1	40,161.2	38,820.1	39,040.3	41,562.1	44,562.1	46,562.1
210101	Үндсэн ажлын цалин	34,756.2	40,161.2	38,820.1	28,139.5	31,165.3	34,165.3	36,165.3
210102	Нэмэгдэл урамшил	9,291.1		0.0	10,900.8	10,396.8	10,396.8	10,396.8
210103	Хоол ,унааны зардал							
210104	Урамшуулал							
210105	Гэрээт ажлын цалин	0.0						
2102	ндш	4,075.8	4,416.9	4,270.3	4,294.5	4,571.8	4,901.8	5,121.8
210201	Тэтгэврийн даатгал	2,593.7	2,810.8	2,593.7	2,732.9	2,909.3	3,119.3	3,259.3
210202	Тэтгэмжийн даатгал	185.3	200.8	185.3	195.2	207.8	222.8	232.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	370.5	401.5	370.5	390.4	415.6	445.6	465.6
210204	Ажигүйдлийн даатгал	185.3	200.8	185.3	195.2	207.8	222.8	232.8

210205	Эрүүл мэндийн даатгал	741.1	803.1	741.1	780.8	831.2	891.2	931.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.0						
210301	Гэрэл цахилгаан	0.0						
210302	Түлш халаалт	0.0						
2104	Хангамж, бараа материалын зардал	9,972.7	6,117.6	5,241.0	3,047.3	10,180.7	10,180.7	11,214.2
210401	Бичиг хэрэг	422.0	348.0	348.0	296.0	966.5	966.5	1,000.0
210402	Тээвэр шатахуун	8,485.3	5,157.4	4,475.4	2,351.3	7,477.5	7,477.5	8,477.5
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	859.3	480.8	417.6	400.0	1,516.0	1,516.0	1,516.0
210404	Ном хэвлэл	206.1	131.4	0.0	0.0	220.7	220.7	220.7
210405	Хог хаягдал цэвэрлэх устгах							
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс							
2105	Нормативт зардал	0.0						
210502	Хоол хүнс							
210503	Нормын хувцас з/эдлэл							
2106	Эд хогшил, урсгал засварын зардал							
210601	Банаж, техник хэрэгсэл							
210602	Тавилга							
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл							
210604	Урсгал засвар							
2107	Томилолт зочны зардал	1,271.0	1,637.0	1,064.1	812.7	2,189.5	3,189.5	3,189.5
210702	Дотоод албан томилолт	1,271.0	1,637.0	1,064.1	812.7	2,189.5	3,189.5	3,189.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах							
2108	БГАҮ, төлбөр хураамж	1,511.1	568.0	394.0	394.0	813.0	813.0	813.0
210801	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	93.0	80.0	80.0	80.0	80.0	80.0	80.0
210802	Даатгалын үйлчилгээ		85.0	85.0	85.0	280.0	280.0	280.0
210803	Мэдээлэл сурталчилгааны зардал	1,148.0						
210804	Тээврийн хэрэгсэлийн Оношлогоо		15.0	15.0	15.0	15.0	15.0	15.0
210805	Тээврийн хэрэгсэлийн татвар			0.0	0.0	50.0	50.0	50.0
210806	Банк санхүүгийн байгууллагын хураамж	51.2						
210807	Газрын төлбөр							
210809	Гэмт хэрэгээс усахз					500.0	1,000.0	1,000.0
210810	Төлбөр хураамж болон бусад зардал	218.9	48.0	48.0	48.0	48.0	48.0	48.0
210811	Газрын зураг							
210812	Газрын хянан баталгаажуулалт							
210818	Төрийн өмнөөс гау		340.0	166.0	166.0	340.0	340.0	340.0
210822	МЭҮйлчилгээ							
210826	Холбооны суваг ашигласан							
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49.8	1,000.0	962.5	962.5	1,250.0	1,250.0	1,250.0
210907	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		750.0	750.0	750.0	1,000.0	1,000.0	1,000.0
210908	Биеийн тамирын уралдаан тэмцээн	49.8	250.0	212.5	212.5	500.0	1,000.0	1,000.0
210910	Орон нутгийн нөөц хөрөнгө							
210911	Ахмадын хороо							

210913	Халамж							
	Хөрөнгийн зардал	0.0	1,000.0	0.0	2,000.0	1,000.0	1,000.0	1,000.0
	Хөрөнгө оруулалт							
	Их засвар							
	Тоног төхөөрөмж		1,000.0	0.0	2,000.0	1,000.0	1,000.0	1,000.0
	Стратегийн нөөц							
2143	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	5,334.5	1,296.0	0.0	0.0	1,296.0	1,296.0	1,296.0
214304	Тэтгэвэрт гарахад олгох 1 удаа тэтгэмж							
214305	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай дэмжлэг							
214305	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	976.7	1,296.0	0.0	0.0	1,296.0	1,296.0	1,296.0
214305	Хуульд заасан үндэслэл	4,357.8						
	ЭХ ҮҮСВЭР БҮГД							
32	ОНТөсвөөс санхүүжих							
320001	Орон нутгийн төсвөөс							
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас							
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас							
350001	- Үндсэн үйл ажиллагааны							
350002	- Туслах үйл ажиллагааны							
350003	Урьд оны үлдэгдэлээс							
61	Байгууллагын тоо	1	1	1	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1	1	1	1
62	Ажиллагсадын тоо	4.0	3.0	3.0	3.0	4.0	5.0	5.0
620001	Удирдах	1	1	1	1	1	1	1
620002	Гүйцэтгэх	2	1	1	1	1	2	2
620003	Үйлчлэх	1	1	1	1	2	2	2
620003	Гэрээт			6	6	6	6	6

ЗУРГАА: ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН

Сумын ИТХ-ын үйл ажиллагааны 2016-2020 оны стратеги, бүтцийн хөтөлбөр хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

6.1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагаа бүрэн төлөвшинө.

6.2. Сумын эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэн бүтцийг төрөлжүүлж, эдийн засгийн өсөлтийг ханган иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлснээр сумын 1 хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 4.5 төгрөгт хүргэнэ.

6.3. Аймгийн эдийн засаг, нийгмийн ногоон хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд баталж орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 30 хүртэл хувийг ногоон хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулдаг болсон байна.

6.4.Жил бүр шинэ ажлын байрыг 50-аар нэмэгдүүлснээр ажилгүйдлийн түвшинг нэг оронтой тоонд хадгална.

6.5.Хүн амыг аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлснээр сумын хүн амын дундаж наслалтыг 71.5-д, халдаварт бус өвчний эрт илрүүлэлтийг 46 хувьд тус тус хүргэж халдварт өвчний тархалтыг улсын дундаж үзүүлэлтийн түвшингээс доогуур байлган эхийн эндэгдлийг 1000 төрөлтөнд 50 промил, 5 нас хүртэлх хүүхдийн эндэгдлийг 1000 амьд төрөлтөнд 21 промил болгон бууруулна.

6.6.Боловсролын үйлчилгээнд стандартад суурилсан тогтолцоог бүрдүүлж, суурь боловсролын хамран сургалтыг 95.0 хувь, цэцэрлэгийн хамрагдалтыг 92.0 хувьд тус тус хүргэж, сурагчдын ЭЕШ-ын үнэлгээг 515 болгон ахиулна.

6.7.Төрийн үйлчилгээнд цахим сүлжээг нэвтрүүлэн, нээлттэй, ил тод, шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй үйлчилгээ бий болж төр захиргааны байгууллагын үүрэг хариуцлага дээшилсэн байна.

...oOo...



ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 49

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Мухраа овогтой Нямхүүг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

2.Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 50

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Очир овогтой Баттулгыг төрийн дээд шагнал “Монгол улсын Эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан” цол тэмдэгээр шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

2.Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 51

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Булган сумын Далт багийн иргэн Оюунбаатар овогтой Оюунчимэгийг төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

2.Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 52

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Булган сумын Далт багийн иргэн Сүхтэй овогтой Нацагням төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

2. Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т. БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 53

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Булган сумын Далт багийн иргэн Гүнзэн овогтой Бадамцэрэнг төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.

2. Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Т. БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 54

Бүрэнхайрхан

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1.Булган сумын Далт багийн иргэн Авирмэд овогтой Үржээг төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар ирүүлсэн тодорхойлолт, саналыг дэмжсүгэй.
- 2.Журмын дагуу материал бүрдүүлэн, холбогдох дээд шатны байгууллагад уламжлахыг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 55

Бүрэнхайрхан

Хяналт тавих чиг үүрэг бүхий
орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 153 дүгээр тогтоолын 3.3.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн ахлагч: Ц.Баасүрэн - сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч, Тэргүүлэгч гишүүн

Гишүүдэд: Ц.Сүхбат – Сумын Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн

К.Онгорбай-Сумын Баянсудал багийн иргэн

Д.Хоролсүрэн – Сумын Байтаг багийн иргэн

Б.Батмөнх-Сумын Алагтолгой багийн иргэн

М.Лувсан-Сумын Далт багийн иргэн

Ч.Булганцэцэг – Сумын Бүрэнхайрхан багийн иргэн

2. Төсөл хяналтын ажлын тайланг хагас, бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж байхыг хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус хяналтын зөвлөлийн ахлагч /Ц.Баасүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 29 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 56

Бүрэнхайрхан

Хуралдааны тов зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удидлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр хуралдааныг 2017 оны 07 дугаар сарын 19-ны өдөр зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.

1.1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны хагас жилд хийсэн ажлын тайлан, цаашдын зорилтын тухай илтгэл

1.2.Сумын Засаг даргын 2017 оны хагас жилийн ажлын тайлан илтгэл, 2016-2020 онд хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлтийн явц

1.3.Сумын 2017 оны газар зохион байгуулалтын хагас жилийн ажлын тайлан, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай илтгэл

Хоёр.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээлэл, материалыг хувиан бэлтгэхийг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

Гурав.Хуралдааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.БАТХУЯГ





ХОВД АЙМАГ
БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 57

Бүрэнхайрхан

Баяр тэмдэглэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйл, сумын Засаг даргын саналыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын үндэсний их баяр наадам, ардын хувьсгалын 96 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Улсын баяр наадмын зардлыг зохих журмын дагуу гаргаж, наадмын үеэр архидан согтуурах, хэв журмын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга /Б.Амгаланбадрах/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Т.Б.ТХУЯГ



УЛСЫН БАЯР НААДАМ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Багийн нэр	Тэмдэглэх газар	Хугацаа
1	Баянгол	Сонгинот	7-р сарын 05-нд
2	Баянсудал	Доод нарийн	7-р сарын 04-нд
3	Байтаг	Сөнхөл	7-р сарын 04-нд
4	Алагтолгой	Ендэрт	7-р сарын 05-нд
5	Далт, Бүрэнхайрхан	Сумын төв	7-р сарын 10-нд

...оОо...